

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Нацаг	Дугаар	L320
Оршин суугаа аймаг	Өвөрхангай	Оршин суугаа сум	Есөн зүйл сумын төв
Төрсөн газар	Зүүнбаян-Улаан сум	Төрсөн он	1925
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хүйтэнгийн хурал, Лавран хийд, Арвайхээрийн хүрээ	Сүм хийдийн дугаар	ӨХЗУ 036, ӨХЗУ 034, ӨХАХ 041
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 6-р сарын 4	Ярилцлага авсан хүн	Жужа



Өвөрхангай аймгийн Зүүнбаян-Улаан сумын Хүйтэнгийн хурал, Лавран хийд, Арвайхээрийн хүрээ

Жужа: Энд сүм хийд байсан уу?

Нацаг: Гэр бүл байсан. Гэр бүлтэй байж байгаад энэ жил нас барсан.

Энхбаяр: Сүм хийд байсан уу?

Нацаг: Байсан л даа, дээр үед. Манай энд анх Мөнхбулаг сум гэж 1931 онд сум байгуулсан юм. Хойно өөрчлөөд Зүүн Баян-Улаан гэж сум байгаа юм. Энүүхэнд Хүйтэн гэдэг хийд байсан. Энэ хэнтийн тал гэдэг газар, халуун үс байдаг юм.

Жужа: Хэдэн дуган байсан бэ?

Нацаг: 4 дугантай байсан юм, жижиг дуганууд байсан .

Жужа: Ямар ямар дуганууд байсан ?

Нацаг: Модон дуган л байсан юм даа.

Жужа: хэдэн лам байсан бэ?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Нацаг: 50-иад лам байсан байх. Энд бас нэг Хүйтэн гэж нэлээн том бас нэг хийд байсан . 5, 6 дугантай. Энэ баруун гол гэдгийн Ёл хайрхан гэдгийн элэг өвөр дээр Хүйтэн гэж нэртэй байсан юм. Энэ нь Ловрон , хойтох нь Хүйтэн гэдэг нэртэй.

Энхбаяр: Ямар нэртэй уул гэнэ ээ?

Нацаг: Ёл хайрхан.

Жужа: 5, 6 дуган байсан юм уу?

Нацаг: Тийм 5, 6 дуган байсан.

Жужа: Хашаа байсан уу?

Нацагш: Хашаатай, модон гэртэй нэлээн том хийд байсан.

Жужа: Тэнд хэдэн лам байсан бэ?

Нацаг: Бас 50, 60-иад лам байсан юм.

Жужа: Суварга байсан уу?

Нацаг. Гурван суварга байсан.

Жужа: Ловронд суварга байсан уу?

Нацаг: Тэнд бас 2, 3 суварга байсан.

Жужа: Энэ хоёр хийдэд том том нэр алдартай лам нар байсан уу?

Нацаг. Өө том том унзад, гавж байсан юм.

Жужа: Тэнд ямар ямар шүтээнүүд байсан бэ?

Нацаг: Өө тэгээд гуулин бурхан, сүүмал бурхан тийм л шүтээнтэй байсан юм.

Жужа: Дандаа дөрвөлжин дуганууд байсан уу, гэр хэлбэртэй юу?

Нацаг: Дандаа дөрвөлжин.

Жужа: Цам цүжиг гардаг байсан уу?

Нацаг: Аа тэгэлгүй яахав. Арай жижигхэн цам гардаг байсан юм.

Жужа: Аль хийдэд?

Нацаг: Хоёуланд л тэгж тоглодог.

Жужа: Өөр сүм хийд байсан уу ?

Нацаг: Энэ Дөлгөөний Хадны монхор гээд байгаа. Тэнд нэг хошууны хүрээ байгаа. Ахай бэйсийн хошуу гэж байсан юм.

Жужа: Тэнд хэдэн дуган байсан бэ?

Нацаг: Тэнд 200-аад лам байсан байх. Мундаг хүрээ байсан юм.

Жужа: Хэдэн дуган байсан бэ?

Нацаг: Их том хүрээ байсан юм, 8, 9 дуган байсан байх.

Жужа: Модон уу, тоосгон уу?

Нацаг: Өө дандаа модон дуган.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Жужа: Хашаан дотор байсан уу?

Нацаг: Зарим нь хашаанд, зарим нь хашааны гадаа байсан. Дандаа л жастай, жасын малтай байсан.

Жужа: Өөр нэртэй байсан уу?

Нацаг: Ахай бэйсийн хүрээ чинь манай суманд харъяалагддаг байсан юм. Хан хөгшний хүрээ, Арвай хүрээ гэж ч ярьдаг байсан юм, нэрийг нь сайн мэддэггүй.

Энхбаяр: Хангай уул гэж хаана байдаг юм?

Нацаг: Хангай овоо гэж арц энэ тэр ургадаг их том уул байдаг юм. Манай сайн ноён хан Намнансүрэнгийн нутаг.

Энхбаяр: Тэнд Бэлийн хүрээ гэж байсан уу?

Нацаг: Хүрээ байгаагүй, ганц хоёр дуган байсан. Лам бясалгаж тэгж байсан юм.

Жужа: Суварга бас байсан уу?

Нацаг: Суварга байгаагүй. Ууланд л ганц хоёр дуган байдаг байсан юм. Тэнд уулын лам нэртэй, буян үйлдэж байдаг тийм лам нар байсан юм.

Жужа: Одоо энэ 3, 4 хийдийн лам байгаа юу?

Нацаг: Аа энэ жил 94-тэй нас барлаа. Самдан лам гэж байгаад. Өөр лам нар нь байхгүй ээ.

Жужа: Энэ хүрээ хийдийг хэдэн онд хаасан бэ?

Наэцаг: Энийг чинь 1939, 1940 онд л нураасан даа.

Энхбаяр: Тэр Ахай бэйсийн хүрээнд Асгат уул гэж байгаа юу?

Нацаг: Байгаа.

Жужа: Тэнд суварга байсан уу?

Нацаг: Байсан, зөндөө суварга байсан. За манай Арвайхээрийн хүрээ гэж Өвөрхангайн хүрээг чинь би очиж манай эцэг гучин найман онд баригдсан, цаазаар авахуулсан. Тэгээд хойтон жил нь ээж мийн баригдаж ухан алдаж унаад нас барсан. Тэгэд би өнчин дүү нартайгаа үлдсэн. Тэрнээс хойш эсэргүүний үлдэгдэл гээд өнчин ишгний ч үнэгүй их ядарч зүдэрч явсан. Энэ ерэн оноос хойш харин хүний тоонд орж сайхан юм үзээд явж л байна. Энэ манай Өвөрхангай чинь Гэндэнгийн нутаг гэдэг нэрийн дор их хэлмэгдсэн шүү дээ. Гэндэн гэж ерөнхий сайд байсан юм. Тэрний нэрийн дор албан хаагч, сэхээтэн, малчин, оюутан, эмч энэ Өвөрхангайг чинь гоц сүйтгэсэн шүү дээ. 1200 хүнийг л цаазаар авсан шүү дээ. Дээд шүүхийн дарга Даншийцоодол, улсын прокурор Чойдогсүрэн, генерал Бадам гэдэг хүн, гээд л энэ томчуудыг чинь Өвөрхангай л бол түүгээд устгачихсан шүү дээ, тэгсэн юм байгаа юм. Энэ доктор Ичинноров бичсэн ийм ном байдаг юм. Энэ дээр манай эцгийн цаазлуулж барьсан, ямар хүн байсан нь энэ дээр бичээтэй байгаа. Гэндэн сайд гэж ийм хүн байсан юм. 12 хүүхэдтэй тийм хүн байсан юм, 4 өргөмөл. Төрсөн 8 хүүхэдтэй тийм хүн байсан. Би чинь 4 өргөмөл ах эгчтэй, эхээс наймуулаа тийм л хүн. Манай эцэг их малтай хүн байсан юм, эсэргүү бүлгийн гишүүн Идэвхтэн гэж. Намайг 16-тай байхад барьж аваачиж, дуганыг чинь буулгаж байсан юм. Тэр том бурхныг чинь сэлмээр хага татаж хаяад л, будааг чинь гоожуулаад л тэгээд том машинаар ачаад л нэг хашаанд буулгана. Сүүлдээ дуганыг нь буулгаад л сэргийлэх, шүүх орохоор яамны гадаа аваачиж тэнд хөрөөдөж авсан юм гэнэ лээ, дуганы

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

модыг.Тэгээд л ном судрыг чинь шатаагаад л . Би чинь эсэргүүний хүүхэд гэж тэнд очиж дуган буулгуулж байсан юм. Би тийм нүгэл хийчихсэн юм даа. Гэхдээ би яагаагагүй, тэр төрийн даалгавраар л...Тэгээд л хашаанд овоолоод л сүүлд нь УБ руу ачсан,тэгээд бүү мэд. Арвайхээрийн хүрээ чинь бараар ном хэвлэдэг их алдартай хүрээ байсан юм. Уянгын хүрээ чинь есөн эрдэнээр ном бичдэг ийм хүрээ байсан юм. Тэгээд энэ түүхийн ухааны эрдэмтдийн бичсэнээр шашнаа устгачихаад, хэдэн малтай улсаа устгачихаад, Өврхангайн энэ төрийн дээд улсуудаа устгачихаад тэгээд 1943 онд Цэдэнбал гэдэг чинь Оросод очоод Николай хаанд хэлсэн байна.Николай хаан тэрийг тэгээд үзэж чадаагүй, яах гэж тэгсэн юм, та нар очиж тэр шашнаа сэргээ гээд. Тэгээд Николай хааны буюнаар шашин чинь хагас хугас нь үлдсэн шүү дээ. Тэрний хүчинд үлдэж байгаад тэгээд дахиж сэргэсэн шүү дээ, их буянтай хүн. Би чинь энэ орос цэрэгт байж байгаад, би бол монгол оросын найрамдлын гишүүн хүн. Үнэмлэхийг нь энэ авран дотроо хийчихээд би Орос ард түмэнд их хайртай. Сталин, тэрний гал хөл болох тэгээд Чойбалсан энэ л устгасан юм шүү дээ. Зөвлөлтийн эрдэмтэд, монголын эрдэмтэд олон жил судаллаа, энэ эсэргүүний хэргийг зохиомол гэдгийг баталсан шүү дээ.

Жужа: Одоо энэ шинээр сэргээсэн сүм хийдүүд байгаа юу?

Нацаг: Байхгүй ээ, байхгүй шүү.Би тэгээд энэ Баян-Улаан суманд ядаж нэг хурлын дацантай болооч ээ гээд л гуйдаг юм.тэгээд л нэг хүн үхэх юм.Тэгээд л Улаанбаатар юм уу, Өвөрхангай явдаг.нэг хүн сан энэ тэрийг тавиад тийм хурлын дацантай болоосой л гэж бодох юм. Манай сумаас сайн сайн лам болсон хүүхдүүд бий бий. Хурлын дацантай болвол ард түмэнд их л хэрэгтэй юм. Одоо номоо уншуулчихлаа гээд сэтгэл санаа нь сайхан л болно. Мүү өвгөн чинь 82-той, хал их үзэж, их л зовлон үзэж явлаа. Би чинь эсэргүүний хүүхэд гэж, цэрэгт байж байж 1945 онд шархдаад, 2 жил гаран болоод. Хугацаа дуусгалгүй ирээд, тэгээд Өвөрмонголыг чөлөөлөх дайнд чинь хугацаа дуусгаагүй болохоор нэр хасаад хаячихсан, алинд нь ч орж чадаагүй.Ингээд л энд л ингээд байж байдаг хүн. Армид 2 жил алба хаасан, 2 үнэмлэх авсан. Ингээд бригадын дарга энэ тэр хийгээд л тэгээд би боловсрол бахйгүй ээ. Гэхдээ би монгол бичиг мэднэ. Кирилл үсгээ мэднэ. Аль альныг нь уншчихна. Ном сонин их унших дуртай. Тэгээд яахав дээ, манай төр яахав дээд талаараа яахгүй, доод тал нь үймээд л байх юм. Ардчилсан намыг л нэг залуу улс юм , энийг гаргаад үзвэл яах бол, болохгүй бол 4 жил хасаад л хаячихна биз. Энэ хуучны юу чинь одоо бас эвсэл ч болж үзлээ...

Энхбаяр: Танай нутагт чинь өөр сүм хийд байсан уу?

Нацаг: Ойр байгаагүй ээ. Миний мэдэх юм байгаагүй.

Жужа: Таниас өөр настай лам хүн байгаа юу?

Нацаг: Байхгүй. Энэ сумын хамгийн их настай нь би байгаа юм. Нэг ерэн хэдтэй лам байсан энэ жил нас барчихлаа.

Жужа: За баярлалаа.

Нацаг: За ажлаа тэгээд сайн хийгээд.Та хоёр чинь хаанах вэ?

Жужа: Унгар.